

Олон улсын тээвэрлэлтийн үйлчилгээ Сэдэв: Ачаа тээвэрлэгчийг сонгох

**Улаанбаатар хот
2018 он**

АГУУЛГА

1. Олон улсын ачаа тээвэрлэлтэд оролцогч талууд.....	3
Ачаа илгээгч буюу худалдагч.....	3
Ачаа хүлээн авагч буюу худалдан авагч.....	4
Ачаа тээвэрлэгч.....	4
Тээвэр зуучын байгууллага.....	5
2. Монгол улсын олон улсын тээвэрлэлтийн өнөөгийн байдал.....	7
Төмөр зам.....	7
Агаарын ачаа тээвэр.....	8
Авто замын тээвэр.....	9
3. Ачаа тээвэрлэгчийг оновчтой сонгох нь.....	10
Ашигласан эх сурвалжийн жагсаалт.....	12

1. Олон улсын ачаа тээвэрлэлтэд оролцогч талууд

Олон улсын ачаа тээвэрлэлтэд ачаа илгээгч буюу худалдагч, хүлээн авагч буюу худалдан авагч болон тээвэрлэгч, тээвэр зууч зэрэг байгууллага, хувь хүн оролцдог. Эдгээр нь тус тусын хүлээсэн үүрэг, хариуцлагын дагуу тээвэрлэлтийн үйл ажиллагаанд оролцож, хүлээсэн үүргээ биелүүлэх, тээвэрлэлтийн янз бүрийн үе шатуудад хүлээх тэдний үүрэг хариуцлага, хийж гүйцэтгэх ажлыг олон улсын хэмжээнд нэгдсэн ойлголтод оруулж Олон улсын худалдааны танхимаас “Олон улсын худалдааны нийлүүлэлтийн нөхцлүүд” буюу “INCOTERMS”-ийг батлан гаргаж олон улсын тээвэрлэлтэд ашиглаж байна.

Олон улсын тээвэрлэлтэд оролцогч бүрийн оролцоо, үүрэг харилцан адилгүй байдаг бөгөөд, эдгээр оролцогчдын хамтын ажиллагааны үр дүнд ачааг тээвэрлэж, хүргэж нийлүүлэх үйл явц амжилттай хэрэгжиж, дэлхий даяар бараа бүтээгдэхүүнийг түгээх, худалдах болон худалдан авах үйл ажиллагаа хэрэгжиж байдаг билээ.

Ачаа илгээгч буюу худалдагч

Ачаа илгээгч буюу худалдагч: Худалдан авагчийн захиалгад нийцсэн тоо, чанар бүхий бараа бүтээгдэхүүнийг тээвэрлэх гэрээнд заасан ачилтын цэгт /агуулах, боомт, буудал гэх мэт/, гэрээнд заасан тээврийн хэрэгсэлд ачиж юм уу боомт буудлын холбогдох албанд хүлээлгэж өгөх үндсэн үүрэгтэй. Ачаа илгээгч буюу худалдагчийн үүргийг авч үзвэл:

- Гэрээнд заасан барааг худалдан авагчид буюу гэрээ байгуулсан тээвэрлэгчид шилжүүлэн өгөх
- Барааг экспортлох үйл ажиллагаатай холбоотой зөвшөөрөл, баталгаа, бичиг баримтыг бүрдүүлэх
- Барааг нийлүүлэх үйл ажиллагаатай холбоотой тээвэрлэлт болон даатгалын гэрээг байгуулах
- Барааг гэрээнд заасан хугацаанд худалдан авагчид нийлүүлэх
- Эрсдэлийг худалдан авагчид шилжүүлэх
- Нийлүүлэлтийн зардлыг гэрээний нөхцөлийн дагуу Худалдан авагч тай хуваалцах
- Нийлүүлэлтийнхээ талаар худалдан авагчид цаг тухайд нь мэдэгдэх

- Тээврийн баримтууд, цахилгаан холбоогоор дамжуулан барааг нийлүүлснээ гэрчлэх
- Нийлүүлж буй барааг шалгаж нягтлах, баглаа боодол, хаяглалтыг ёс журмын дагуу хийж гүйцэтгэх.
- Бусад

Ачаа хүлээн авагч буюу худалдан авагч

Ачаа хүлээн авагч буюу худалдан авагч: Худалдагчийн илгээсэн барааг бүрэн бүтэн хүлээн авч, захиалгын дагуу бараа бүтээгдэхүүнийг хүлээн авснаа нотлох, төлбөрийг гэрээнд заасны дагуу саадгүй төлөх үндсэн үүрэгтэй. Ачаа хүлээн авагч буюу худалдан авагчийн үүргийг авч үзвэл:

- Нийлүүлсэн барааны үнийг төлөх
- Нийлүүлж буй барааг импортлох үед зөвшөөрөл, баталгаа болон холбогдох бусад бичиг баримтуудыг бүрдүүлэх
- Тээвэрлэлт болон даатгалын гэрээг байгуулах
- Нийлүүлсэн барааг хүлээн авах
- Гэрээнд заасан нөхцөлийн дагуу эрсдэлийг шилжүүлэн авах
- Гэрээнд заасан нөхцөлийн дагуу худалдагч талтай нийлүүлэлттэй холбогдон гарсан зардлыг хуваалцах
- Худалдагч талтай барааны нийлүүлэлтийн талаар харилцан мэдээлэл солилцох
- Тээврийн баримтууд, тэдгээртэй дүйцэх цахилгаан холбооны хэрэгслээр дамжуулан барааг хүлээн авснаа гэрчлэх
- Нийлүүлсэн барааг шалган магадлах
- Бусад

Ачаа тээвэрлэгч

Ачаа тээвэрлэгч: Худалдан авагч эсвэл худалдагчийн хүсэлтээр зохих тоо хэмжээний ачаа барааг, гэрээнд заасан ачилтын цэгээс буулгах цэг хүртэл, аюулгүй, тогтоосон хугацаанд хүргэж өгөхөөр үүрэг авсан аливаа этгээдийг ачаа тээвэрлэгч гэж үзнэ. Ачаа тээвэрлэгч дараах үүрэг хүлээнэ:

- Ачаа тээшийг тогтоосон газар хүргэх
- Ачаа тээвэрлэх зориулалт бүхий тээврийн хэрэгслээр ачаа барааг тээвэрлэх, ачаа барааг тээвэрлэхдээ тээврийн хэрэгслийн зохих

стандарт нөхцлийг хангасан эвдрэлгүй тээврийн хэрэгслээр ачаа барааг тээвэрлэх

- Тээвэрлэгч нь тээвэрлэлтэд ашиглаж буй тээврийн хэрэгсэлтэй холбоотой аюулгүй байдлын дүрэм, журмыг биелүүлэх
- Тээвэрлэгч нь ачаа бараа тээвэрлэхдээ холбогдсон бусад зардлыг өөрөө дангаар хариуцах /бензин, моторын тос, тээврийн хэрэгсэлд шаардлагатай сэлбэг, багаж хэрэгсэл, хоол хүнс/
- Ачаа барааг хүлээн авснаас хойш хүлээлгэн өгөх бүхий л хугацаанд гэрээнд зааснаар ачаа алдагдсан, дутсан, гэмтсэн, эвдэрсэн түүнчлэн тээвэрлэлтийн хугацаа хожимдуулсан хариуцлагыг дангаар өөрийн эд хөрөнгөөр хариуцах
- Дагалдах бичигт хавсаргасан буюу өөрөө хүлээн авсан баримт бичгийг үрэгдүүлсэн, буруугаар ашигласны хариуцлагыг хүлээх
- Тээвэрлэгчид итгэмжлэн өгсөн ачаа нь онцгой ач холбогдолтой бол түүнийг хамгаалах нэмэлт арга хэмжээ авах
- Тээвэрлэгч нь тээвэрлүүлэгч болон бусдад учруулсан хохирлыг өөрийн эд хөрөнгөөр хариуцах
- Бусад

Тээвэр зуучын байгууллага

Тээвэр зуучын байгууллага: Орчин үед бараа бүтээгдэхүүний эргэлт нэмэгдэхийн хажуугаар дэлхий даяар олон нийлүүлэгч, олон төрлийн худалдан авагч энд тэндгүй тархан байрлаж байна. Тиймээс олон улсын хэмжээнд ачааг тээвэрлэх, хүргэж өгөх үйл ажиллагаанд тээвэрлэгч болон хэрэглэгчдийг холбодог мэргэшсэн байгууллага болох тээвэр зуучийн байгууллагын гүйцэтгэх үүрэг улам бүр өсөж байна.

Тээвэр зууч бол хувь хүн, аж ахуйн нэгжийн ачаа барааг зөөвөрлөх, үүнтэй холбогдон гарах бүх төрлийн асуудлыг зохицуулж зуучилдаг компани юм. Ихэнх тээвэр зуучууд гардан тээвэр хийдэггүй бөгөөд тээвэрт 3-дагч тал болон оролцдог.

Тээвэр зууч бол тухайн ачаа бараанд ямар төрлийн тээвэр зохицох тухайг мэргэжилтний зүгээс харж агаарын тээврийн, усан замын тээврийн,

төмөр замын тээврийн, авто замын тээврийн төрөлжсөн компаниудтай холбогдон тэдгээрт тухайн ачаа бараанд тохирох төрөлийг тодорхойлж зай талбайн захиалга хийж тээвэрлэлтийг зохицуулдаг.

Тээвэр зуучийн байгууллагын үүрэг нь:

- Тээвэрлүүлэх ачааг ямар төрлийн тээврийн хэрэгслээр тээвэрлэхийг илүү зохимжтой болохыг тодорхойлон тээврийн байгууллага, тээвэрлэгч хоёрыг холбон, ачааг заасан хугацаанд тээвэрлүүлэх, тээврийн үйл ажиллагаатай холбоотой гааль, даатгал болон холбогдох бичиг баримтыг бүрдүүлэн, тээвэрлэлтийг саадгүй зохион байгуулах
- Тээврийн үйл ажиллагаанд оролцогч талуудыг мэдээллээр ханган хамгийн хямд зардлаар тээвэрлэх нөхцөл бололцоог санал болгох
- Олон улсын тээвэрлэлтийн талаар мэдээлэл түгээх, зөвлөгөө өгөх
- Бусад

Эдгээр үндсэн оролцогчдын хамтын ажиллагааны үр дүнд олон улсын хэмжээнд ачаа тээвэрлэлт саадгүй явагдаж дэлхий даяар бараа бүтээгдэхүүнийг түгээн, худалдан авагчдыг хэрэгцээт бараагаар хангаж байна.

2. Монгол улсын олон улсын тээвэрлэлтийн өнөөгийн байдал

Манай улсын тээвэр нь авто зам, төмөр зам, агаарын, усан замын тээвэр гэсэн 4 үндсэн төрлөөс бүрдэнэ. Эдгээрээс усан замын тээвэр нь гадаад улстай шууд харилцах боломжгүй буюу Хөвсгөл нуур дээрх орон нутгийн шинж чанартай тээвэрлэлт хийдэг.

Төмөр зам

Төмөр зам: Монгол улсыг гадаад ертөнцтэй холбодог гол судас нь төмөр зам юм. Төмөр зам нь зөвхөн дотоод тээвэр төдийгүй экспорт, импортын дамжин өнгөрөх ачаа тээвэрлэлтэд шийдвэрлэх үүргийг гүйцэтгэдэг.

Энэ зууны эхээр буюу Олноо өргөгдсөн дөрөвдүгээр /1915/ онд Монгол Улсын эзэн хаан VIII Богд Жавзандамба хутагтаас Улсын Дээд хурлын сайд, түшмэдэд өргөн барьсан бичигт уул уурхайг хөгжүүлэх, төмөр зам барих тухай дэвшүүлж байсан санаа Улаанбаатар-Налайхын хооронд нарийн царигийн төмөр замыг 1938 онд ашиглалтанд оруулсанаар биеллээ олжээ. Нийт урт нь 43 км, жилд зуу гаруйхан мянган тонн ачаа тээвэрлэж байсан Монголын төмөр зам өдгөө 1815 км урттай, улсын нийт ачаа эргэлтийн 90 гаруй хувийг гүйцэтгэн, Монгол улсын дэд бүтцийн салбарт онцгой байр эзлэж байна.

Монголын төмөр замын өргөн нь 1520 мм бөгөөд энэ нь ОХУ-ынхтай нэг ижил хэмжээнд, БНХАУ-ынхаас 90 мм-ээр илүү өргөн байна гэсэн үг юм.

Монголын төмөр замын олон улсын тээвэрлэлтэд ашиглаж буй бүх төрлийн зүтгүүр болон вагонууд өргөн төмөр замд зориулагдсан байдаг тул төмөр замаар тээвэрлэж буй ачаа нь хөрш ОХУ-ын төмөр зам руу тээврийн хэрэгсэлтэйгээ шууд нэвтрэн орох боломжтой. Мөн ОХУ-аас ачигдсан экспортын буюу транзит ачаа нь Монголын төмөр зам руу тээврийн хэрэгсэлтэйгээ хамт нэвтрэн орох боломжтой юм.

Хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд байсан орнуудаас өөр улс орнууд өргөн төмөр замыг ашигладаггүй.

Ялангуяа Монголын гадаад худалдааны томоохон түнш, экспорт импортын, транзит ачааны дийлэнх хувь нь дамжин өнгөрдөг хөрш Хятад улсын төмөр замын өргөн нь манайхтай ижил биш байгаа нь манай улсын

олон улсын ачаа тээвэрлэлтэд нэмэлт зардал бий болгодог. Манай төмөр замын өргөн нь Хятадын төмөр замын өргөнтэй ижил биш учир төмөр замын дагуух хилийн боомтууд дээр зайлшгүй шилжүүлэн ачилт хийх шаардлагатай байдаг.

Шилжүүлэн ачилтын тоо нэмэгдсэнээр барааг нийлүүлэх ба хүлээн авах хугацаа удааширч, экспорт импортын барааны өртөг зардал улам бүр өндөрсөж байгаа юм.

Замын одоогийн нөхцөл байдал нь Хятадын нутаг дэвсгэрээр дамжуулан түргэн гэмтэж муудах бараа ялангуяа хүнсний бүтээгдэхүүнийг экспортлох, импортлох боломжийг хязгаарлаж байна. Монголын нутгаас төмөр замаар тээвэрлэгдэн гарч буй экспортын болон транзит ачаа нь БНХАУ-ын хилийн Эрээн боомтод, БНХАУ-ын нутаг дэвсгэрээс ачигдсан импортын буюу транзит ачаа нь Монгол улсын Замын үүд боомтод тус тус шилжүүлэн ачилтад орж байж тээвэрлэгдэж байна.

Агаарын ачаа тээвэр

Агаарын ачаа тээвэр: Далайд гарцгүй эх газрын орны хувьд агаарын тээвэрлэлт нь Монгол улсын олон улсын тээвэрлэлтийн үндсэн нэг хэлбэр юм.

Монголд өмчийн янз бүрийн хэлбэрийн хэд хэдэн компаниуд үйл ажиллагаагаа явуулж байна.

1994 оноос эхлэн иргэний агаарын тээврийн зорчигч тээвэрлэлтийн хэмжээ өсөх хандлагатай болсон хэдий ч ачаа тээвэрлэлтэд өөрчлөлт гарахгүй байна. Монгол улсын экспорт, импортын нийт ачааны дийлэнх нь овор хэмжээ ихтэй боловсруулаагүй түүхий эд буюу хагас боловсруулсан бүтээгдэхүүн байгаа нь ачааг олон улсын хэмжээнд агаараар тээвэрлэх боломжийг бууруулж буй нэг хүчин зүйл мөн.

Манай улсад агаарын тээврийн борлуулалт эрхэлдэг компаниуд нэмэгдэж байгаатай холбогдуулан тодорхой шаардлага хангасан дотоодын компаниудтай агентын гэрээ байгуулан ажиллаж эхэлсний зэрэгцээ ачаа тээвэрлэлтийн орлогыг нэмэгдүүлэх зорилгоор зарим оронд ачаа тээвэрлэлтийн борлуулагч агентуудыг шинээр томилон ажиллуулж байна.

Авто замын тээвэр

Авто замын тээвэр: Өргөн уудам нутагтай цөөн хүн амтай, орон нутгийн зах зээл хязгаарлагдмал манай орны хувьд авто тээвэрлэлт хамгийн ашигтай ба оновчтой ачаа тээвэрлэлтийн хэлбэр бөгөөд ирээдүйд энэ байдлаа алдахгүй юм.

Манай улс сүүлийн жилүүдэд авто замын бүтээн байгуулалтыг эрчимтэй хийж байгаа боловч олон улсын чанартай авто зам хараахан бүтээн босгож чадаагүй байна.

Өмнөд хил Замын-Үүд, Хойд хил Алтанбулаг хүртэл хатуу хучилттай замтай боловч хүнд даацын ачааны автомашинд тохиромжгүй нарийн замтай учир олон улсын авто замын тээвэрлэлт дорвитой хөгжихгүй байна.

Хэдийгээр уул уурхайн бүтээгдэхүүнийг автомашинаар тээвэрлэж байгаа боловч бэлэн бүтээгдэхүүний тээвэрлэлтийн хэмжээ бага байдаг байна. Автомашиныг ашиглан хилийн худалдаанд ачаа барааг бага хэмжээгээр тээвэрлэж байна.

3. Ачаа тээвэрлэгчийг оновчтой сонгох нь

Олон улсын тээвэрлэлтээр дамжин бараа бүтээгдэхүүн дэлхий даяар тарж, хэрэглэгч үйлдвэрлэгчдийг холбодог болохыг бид өмнөх хичээлүүдээр үзлээ.

Үйлдвэрлэгч, экспортлогчийн хувьд тэдний хэрэглэгч нь алслагдсан байдаг учир тээврийн зардлаа багасгах, ингэснээрээ бараа бүтээгдэхүүний үнийг их хэмжээгээр өсгөхгүй байлгаж, өрсөлдөх чадвараа хадгалж үлдэх эрмэлзлэлтэй байдаг.

Монгол улсын хувьд далайгаас алслагдсан газарзүйн байрлал, дэд бүтцийн сул хөгжлөөс шалтгаалаад олон улсын тээвэрлэлтийн өртөг зардал ерөнхийдөө өндөр буюу үнийн дүнгийн 20 орчим хувьтай тэнцүү байдаг гэсэн тооцоо байдаг. Тиймээс нийт экспортлогчдын хувьд тулгардаг асуудал нь тээвэрлэлтийн зардлаа хэрхэн бууруулах болон тээврийн хэрэгслээ хэрхэн оновчтой сонгох тухай асуудал юм. Тээврийн өртөг зардлаа багасгах хоёр төрлийн арга зам байдаг. Үүнд:

1. Нийлүүлэх барааны хэмжээг нэмэгдүүлэх замаар нэгж бүтээгдэхүүнд ногдох тээврийн зардлаа бууруулах.
2. Хил залгаа буюу хамгийн ойр байршилтай гадаад зах зээлд бараа бүтээгдэхүүнээ худалдах.

Жижиг дунд үйлдвэрлэгчдийн хувьд бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээгээ өсгөх технологийн, санхүүгийн болон бусад хязгаарлалтаас хамааран үйлдвэрлэлээ өргөжүүлэх нь хүндрэлтэй байх тохиолдол бий. Хэрэв үйлдвэрлэлийн хэмжээгээ нэмэгдүүлэх боломж хязгаарлагдмал бол хоёрдох арга замыг буюу хил залгаа улсын зах зээлд бараа бүтээгдэхүүнээ худалдан борлуулах аргыг ашиглах нь оновчтой байх талтай.

Монгол улсад олон улсын тээвэрлэлт хийдэг гурван төрлийн тээврийн салбар байгаа тухай дээр үзсэн. Эдгээр салбарууд нь өөр өөрийн онцлог шинжийг агуулдаг учир экспортлогч сонголтоо хийхдээ дараах асуултуудыг хариулсан байх шаардлагатай. Үүнд:

- ✓ Ямар улсын зах зээлийг сонирхож байгаа, зорилтот зах зээлийн газарзүйн байршил хаана байгаа вэ?

- ✓ Манай компанийн бараа бүтээгдэхүүн ямар зэрэглэлийн бүтээгдэхүүн бэ? /ердийн, өргөн хэрэглээний, тансаг хэрэглээний, өндөр технологийн гэх мэт/
- ✓ Манай үйлдвэрлэсэн бараа тээвэрлэлт хадгалалтын онцгой нөхцөл шаарддаг эсэх?
- ✓ Манай бараа бүтээгдэхүүний сав, баглаа боодол тусгай нөхцөл шаарддаг эсэх?
- ✓ Бараа бүтээгдэхүүний жин, овор хэмжээ, нэг удаагийн ачилтаар хичнээн хэмжээгээр ачих боломжтой вэ?
- ✓ Ачилт хийх давтамж?
- ✓ Бараа бүтээгдэхүүний үнэ?
- ✓ Бусад онцлог шинжүүд

Дээрх асуултуудад хариулсны дараа, эсвэл дээрх асуултуудын хариуг тээвэр зуучийн байгууллагатай харилцан зөвшилцөж зөвлөгөө авсаны үндсэн дээр тээврийн хэрэгслийн сонгох нь оновчтой.

Ашигласан эх сурвалжийн жагсаалт

1. Батнасан.Н., (2003), “Гадаад худалдаа: Үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалт, эрх зүйн зохицуулалт”, хуудас 223-243.